

**“АРХАНГАЙ АЙМАГТ УС ЦАГ УУРЫН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭЖ ХӨГЖИСНИЙ
ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙ”-Д
ЗОРИУЛСАН СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ
УДИРДАМЖ**

2026 оны 05 дугаар сарын 14

Эрдэнэбулган сум

Нэг. Зорилго

“Архангай аймагт УС ЦАГ УУРЫН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙГ” угтан хамтран ажилагч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, ажилтан албан хаагчидын бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, хамт олны эв нэгдэл идэвх санаачлагыг нэмэгдүүлэх, нөхөрсөг харилцааг бэхжүүлэхэд энэхүү спортын арга хэмжээний зорилго оршино.

Хоёр. Спортын тэмцээний төрөл, бүрэлдэхүүн

- 2.1. Гар бөмбөгийн төрөлд эрэгтэй -4, эмэгтэй -4
- 2.2. Тениссний төрөлд байгууллага бүрээс эрэгтэй -1, эмэгтэй -1
- 2.3. Корнхолл төрөлд байгууллага бүрээс эрэгтэй 2, эмэгтэй 2 тамирчин

оролцоно.

Жич: Нэг тамирчин 2-оос дээш төрөлд оролцохгүй.

Гурав. Зохион байгуулагч

Ус цаг уур орчны шинжилгээний төв

Ойн арга хэмжээ зохион байгуулах комисс

Дөрөв. Оролцох байгууллага:

Архангай аймгийн ЗДТГ

Эрдэнэбулган сумын ЗДТГ

- Байгаль орчины газар
- Хүнс, хөдөө аж ахуйн газар
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
- Онцгой байдлын газар
- Архангай аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасаг
- Экологийн асуудал хариуцсан алба хаагчид
- Мал эмнэлэгийн газар
- Ус цаг уур орчны шинжилгээний төв
- Стандарт, хэмжил зүйн хэлтэс
- Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа
- Орхон-Чулуут голын сав газрын захиргаа
- Сум дундын ой анги
- Ар-Ус Ундарга ХХК

Тав. Тэмцээн зохион байгуулах хугацаа, оролцох тамирчдын бүрэлдэхүүн, зохион байгуулалт

.Тэмцээнийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 09:00 цагаас АРА АРЕНА-д зохион байгуулагдана.

Жич:

1.Талбай дээр 10 минут хүлээж, ирээгүй тохиолдолд тухайн тоглолтод хожигдсонд тооцно.

2.Тэмцээнд 14 байгууллагын үндсэн ажилтнууд оролцоно. /6 сараас дээш, НДШ лавлагаа, иргэний үнэмлэхний хуулбар.

3.Мэдүүлэгт нэр нь дурдагдаагүй тамирчдыг тэмцээнд оролцуулахгүй.

4.Тамирчид хоол хүнс болон хувийн бэлтгэл, тэмцээнд ирж, очих аюулгүй байдлаа өөрсдөө хангах.

5. Багийн тамирчид жигдэрсэн хувцас, хувийн дугаартай байна.

6. Тамирчид тэмцээнд оролцохдоо архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн бол тэмцээнээс хасна.

7. Нэг багаас гаргах бооцооны мөнгө 300,000 (гурван зуун мянган) төгрөг байна.

8. Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хийх бөгөөд техникийн зөвлөгөөн дээр багийн ахлагч, төлөөлөн багийн тамирчидын мэдүүлэг болон бооцооны мөнгөтэй ирнэ.

Зургаа.Тэмцээнийг дүгнэх журам

6.1 Тэмцээний төрөл тус бүрт I, II, III байр шалгаруулна. Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал.

6.2 Гар бөмбөгийн төрөлд эрэгтэй , эмэгтэй шилдэг тамирчин тодруулна.

Холбоо барих утасны дугаар: 99881890, 89061451

.....000